БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Л.БЯМБАСҮРЭН

2020 оны 05 дугаар сарын 12-ны өдөр

# АГААРЫН ХӨЛГИЙН АЧАА ТЭЭШНИЙ ТУУЗАН ДАМЖУУЛАГЧИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## 1. Ерөнхий шаардлага

Туузан дамжуулагч нь зорчигчдын ачаа тээшийг агаарын хөлөгт ачих, буулгах зориулалттай бөгөөд ашиглалтын хувьд найдвартай, техникийн үйлчилгээ явуулахад хялбар байхын дээр цахилгаан ба гидравлик тоноглол нь хамгийн сүүлийн үеийн технологи ашиглан хийгдсэн байна.Туузан дамжуулагч нь агаарын хөлөгт үйлчлэх үед аль болох хялбар удирдлагатай, аюулгүй байдлыг урьдчилан хангах боломжтой байна.

Манай орны цаг агаарын байдал нь жилийн дөрвөн улиралдаа огцом өөрчлөгддөг, агаарын хэм нь өвөлдөө - 40°C, зундаа + 40°C хүрч хэлбэлзэлдэг тул тоног төхөөрөмжийн эд ангиуд дээрх цаг агаарын нөхцөлд тохирсон байх шаардлагатай.

Мөн дээрх трактор нь манай орны цаг агаартай ижил төстэй оронд нийлүүлэгдэж, тэнд ашиглагдаж байгаа нь тодорхойлогдсон, TLD NBL эсвэл түүнтэй дүйцэх загварын 2019-2020 онд үйлдвэрлэгдсэн шинэ, жолоочийн бүхээгтэй байна.

## 2. Стандарт шаардлага

ISO9001, MNS4598:2003 “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах ерөнхий шаардлага”, IATA-AHM 9108 “Basic requirements for aircraft ground support equipment”, IATA- AHM 925 “Functional specification for a self-propelled conveyor-belt loader“ зэрэг стандарт шаардлагыг хангасан байна.

## 3. Техникийн үзүүлэлт

### 3.1 Автомашины үзүүлэлт

| | |
|---|---|
| Зориулалт : | Ачаа тээшний туузан дамжуулагч |
| Шатахууны төрөл: | Дизель |
| Хөдөлгүүр: | Deutz, Isuzu эсхүл түүнтэй дүйцэх загварын дизель хөдөлгүүртэй |
| Цилиндрийн тоо: | 4 буюу түүнээс дээш |
| Хурдны хайрцаг: | Автомат урагшаа 2-оос 3, ухрах 1 араатай |
| Жолооны хүрдний байрлал: | Зүүн буюу LHD |
| Жолоочийн бүхээг: | Шаардлагатай |
| Жолооны механизм: | Гидро хүчлүүрт |
| Тоормосны систем: | Шингэнт хүчлүүртэй |
| Тэнхлэг: | 4x2 буюу хойд тэнхлэг нь хөтлөх |

### 3.2 Тусгай тоноглол

- Ачаа даац нийт 1200 кг
- Сумны өргөж буулгах удирдлага бүхээгт байрласан байх
- Туузны удирдлага сумны урд болон хойд талд байрласан байх
- Сумны урт 7800 мм, түүнээс дээш байх

- Туузны өргөн 600 мм, түүнээс дээш байх
- Сумны өргөгдөх өндөр урд хэсэг 4000 мм, хойд хэсэг 1200 мм байх
- Ачаа шилжүүлэлтийн хурд 160-500 мм/сек байх
- Туузны хойд хэсгээс хурдыг тохируулах боломжтой байх
- Техникийн эвдрэл гэмтэл, ааварын үед хэрэглэх цахилгаан гидронасос буюу гар удирдлагатай насостой байх
- Сумны 2 хажуугаар ачаа унахаас сэргийлсэн хашлага /өндөр 60-80см/-тай, эвхэгддэг байх
- Дамжуулагчийн урдаа домкрат тулгууртай байх
- Урд болон хойд хэсэгт гэрэлтүүлэгтэй байх
- Хянах самбар, туузны урд болон хойд талд ааварын унтраалгатай байх
- Цахилгаан тэжээл салгагч /Master switch CE/-тай байх
- Кардан голонд хөдөлгөөний чиглэл хамгаалсан мэдрэгчтэй байх
- Зогсоолын тоормостой байх

**3.3 Нэмэлт тоноглол**

- Хүйтний улиралд бүхээгийг дулаацуулах систем байх
- Дулааны улиралд бүхээгийг агааржуулах систем A/C байх
- ASD тоноглолтой байх
- Жолоочийн хаалганы шил нээгддэг байх
- Анхааруулах дуут дохиотой байх
- Ухрах үед анхааруулах дуут дохиотой байх
- Урд болон арын цонхонд шил арчигчтай байх
- Мотоцагийн тоолууртай байх
- Хажуу болон арын харах тольтой байх
- Маяктай байх /чанарын шаардлага хангасан/
- Домкраттай байх
- Түлхүүр багажтай байх /дугуйн торцов болон түлхүүрийн ком/
- Нөөц дугуйтай байх
- Дугуйн ивүүртэй байх
- Галын хортой байх /кабинд 1 ширхэг/

**4 Бусад нөхцөл**

- Автомашины ашиглалт, сүүлийн үеийн нэмэлт тоноглол болон засвар үйлчилгээний талаар үйлдвэрлэгчийн сургалт зохион байгуулах
- Ашиглалтын болон техник үйлчилгээ, засварын гарын авлага, сэлбэгийн каталоги англи хэл дээр байх /Owner manual, Parts catalog, Service manual/
- Техник үйлчилгээнд шаардлагатай сэлбэг материал тус бүр 2 ширхэг /тосны шүүр, түлшний шүүр, агаар шүүгч, цилиндрүүдийн сальник резин, жийргэвч, тос тослох материал/
- Баталгаат хугацаа 2 жил

ХЯНАСАН:
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГА П.МӨНХЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА Д.МАРАЛХҮҮ

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ГИШҮҮД

Д.БАТЦООЖ

Б.ЭНХ-АМГАЛАН

П.ГАНТУЯА

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.МӨНХБААТАР